

Монголын социализм хэрхсэн бэ?

Мураи Мүнэюүки

Монгол оронд үндэсний эрх хөдөлгөөн ялж (1921), социалист замд орсон. Энэ нь "Хөрөнгөтний бус хөгжлийн зам" байсан гэж үзвэл, онолын үүднээс онцгой зүйл гэж ойлгогдохуйц байлаа. Гэвч онцгой зүйл бус Монголын уламжлалд тулгуурласан түүхэн замнал байв. Улс төр, эдийн засгийн эрх чөлөөний хязгаарлалт гэдэг сөрөг талыг илрүүлэн гаргаснаар уг хувьсгалт хөдөлгөөн өрнөсөн юм (1980). Үүнийг "Монголын ардчилсан хөдөлгөөн" гэдэг.

Монголын ардчилсан хөдөлгөөн (1989-1990)-ий зорилго нь тухайн үеийн Монголын социализмын дутагдалтай талыг арилгах байлаа.



(1989 оны 12 сарын 10. Залуучуудын соёлын төвийн өмнө болсон цуглаан)




(Тэдний лозунгийн нэг. "Хүнд суртлыг устгах"-ыг шаардаж буй нь)

Монголын ардчилсан хөдөлгөөн гурван урсгалтай. Үүний нэг нь, ардчилсан хөдөлгөөнд шууд оролцоогүй Содном тэргүүтэй урсгал. Тэд дан ганц социалист орнуудтай бус дэлхийн олон орнуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэхийг эрмэлзэж байлаа. Тэдний дунд Улсын статистикийн газарт ажиллаж байсан Намжим, Жасрай нар байсан юм.



Хоёрдахь нь, Нэргүй, Бошигт нар тэргүүтэй урсгал ЗХУ-ын “Колончлол”-ыг эсэргүүцэж байлаа. Тэд, эхэн үедээ ардчилсан хөдөлгөөнийг чиглүүлж байсан юм.



(Зүүн гар талд Нэргүй, баруун гар талд Бошигт)

Гуравдахь нь тухайн үеийн нийгмийн хатуу чанга захиргаадалтанд дургүйлхэн, “эрх чөлөө”-г эрэлхийлсэн хүмүүс байлаа. Гэхдээ энэхүү “эрх чөлөө” нь үүрэг хариуцлагаас ангид, эмх цэгцгүй эдийн засгийн эрх ашигыг агуулсан байлаа. Үүнд, П.Очирбат (Ерөнхийлөгч асан, Монголын уул уурхайн холбооны тэргүүн), Гончигдорж (Бичиг номынхоны урсгал), Бат-үүл, Элбэгдорж, Дорлигжав (Гүйцэтгэх бүлэг, өлсөглөнд оролцсон) нар орж байв. Ардчилсан хөдөлгөөний үед эдгээр хүмүүс гол цөм нь болж байлаа. Эдгээр янз бүрийн бүлэглэлүүдийг Зориг “зохицуулж”байлаа. Тиймээс дэлхийн хүн төрлөхтөн Зоригыг “Монголын ардчилсан хөдөлгөөн”-ий нүүр царай гэж ойлгодог.



С.Зориг
Сүхбаатарын талбай 1990.4.27. 16.00

(Чанга яригч барьсан Зориг)



(Дундах нь Зориг, зүүн гар талд нь Энхтөвшин)



Монгол улсын төр, засгийн дээд удирдлага
Улаанбаатар хот 1990.07.11

(Зүүн гараас, Ерөнхий сайд Бямбасүрэн, Ерөнхийлөгч Очирбат, Улсын бага хурлын дарга бөгөөд дэд ерөнхийлөгч Гончигдорж)



Монгол Улсын
Улсын Бага хурлын дарга
Раднаасүмбэрэлийн Гончигдорж

(Гончигдорж)



(Бат-үүл)



(Элбэгдорж)



1990 оны 3-р сарын өлсгөлөн



Улс төрийн өлсгөлөн
1990.3.7-9

(1990 оны 3 дугаар сарын 7-ноос 9-ний өдрүүдийн өлсгөлөн)

Энэхүү ардчилсан хөдөлгөөний үр дүн нь нийгмийн хувьд Монголын нийгэмд шилжилт хөдөлгөөний эрх чөлөө олгож, улс төрийн хувьд олон намын болон ерөнхийлөгчийн тогтолцоог буй болгож, дангаараа дарангуйлан захирах нэг намын улс төрийн ноёрхолыг зогсоосон, эдийн засгийн хувьд ард түмний эдийн засгийн үйл ажиллагааны бүх талын эрх чөлөө, олон улсын худалдааны эрх чөлөөг авч ирж, цэрэг армийн хувьд ЗХУ цэрэгээ татаж, улсыг балан хамгаалах зөвлөлийн хурал (Хурлын дарга нь Ерөнхийлөгч) байгуулагдсан зэрэг явдал юм.

Энэхүү “өөрчлөн шинэчлэх” хөдөлгөөн нь тодорхой үр дүнд хүрсэн юм. Энэ нь “Монгол улсын үндсэн хууль” (1992 он) болон бусад хуулиуд юм.

Өөрөөр хэлбэл, Монгол улсын үндсэн хууль нь 1921 онд (Хөрөнгөтний бус хөгжлийн зам), 1940 онд (Социализмын материал техникийн бааз суурь байгуулах), 1960 онд (Социализмийн бааз суурийг байгуулж дуусгах) гэх мэтээр өөрчлөгдсөөр ирсэн бөгөөд 1992 онд шинэ үндсэн хууль (Социализмийн ардчилалд шилжих) батлагдав.

1992 оны үндсэн хуулийн онцлог нь хувийн өмчийн хязгаарлалтыг арилгаж, анхан шатны шүүх дэх иргэний оролцоог нэмэгдүүлж, улсын болон хувийн өмчийн тогтолцоо зэрэгцэн оршиж болох болгож, шилжилт хөдөлгөөнийг чөлөөтэй болгож, ардчилалыг зорьсонд байгаа юм. 1992 оны үндсэн хуулийн дараа олон хууль тогтоомжууд гарсан. Хөдөлмөрийн хууль (1991 он)-иар хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийг дэмжих, Засаг захиргааны хууль (1993 он)-иар аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд засгийн газраас тавих хяналт, эдийн засгийн зохицуулалт, Иргэний хууль (1994 он)-иар хувийн болон улсын өмчийн холимог тогтолцоон, хөрөнгө хамтран эзэмших, газар өмчлөх, улсын мэдлийн газарыг иргэдэд ашиглуулах журам зэргийг тодорхой болгосон юм. Эдгээр нь 1990 оноос өмнөх социализмийн залгамжлал юм.

1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр
Улаанбаатар хот
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ

1 дүгээр зүйл

1. Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.

2. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

2 дугаар зүйл

1. Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна.

2. Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.

3 дугаар зүйл

1. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.

2. Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно.

4 дүгээр зүйл

1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна.

2. Монгол Улсын хилийг хуулиар бататгана.

3. Хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно.

5 дугаар зүйл

1. Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өөрөөр онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.

2. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.

3. Өмчлөгчийн эрхийг гэгцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.

4. Төр нь үндэсний эдийн засгийн ахуйгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийтийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.

(1992 оны үндсэн хуулийн нэгдүгээр бүлэг)

Өөрчлөлтийн тухайд бол, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль (1993 он)-д гадаадын хөрөнгө оруулалтыг улсын өмч болгохгүй байх, хохирлын баталгаанд монголын болон гадаадын иргэдийг адил тэгш хандах, монгол хүний ажлын үнэлэмжийн үүрэг хариуцлага, Төрийн өмч болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996 он)-д Төрийн өмчийн хороо (Төрийн өмчит аж ахуйн нэгжийг хянаж, удирдах байгууллага)-ны эрх мэдлийг тодорхой болгосон зэрэг юм.

Өөрөөр хэлбэл, хольмог эдийн засаг, зах зээлийн эдийн засагт шилжих, эдийн засгийг чөлөөлөх, олон намын тогтолцоо, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, нийгмийн хамгааллыг өргөжүүлэх, сургалтыг төгөлдөржүүлэх, зах зээлийн зарчимд шилжих зэргээс үндэслэн 1990 оноос өмнө байсан хязгаарлагдмал улс төр, эдийн засгийн харилцааг арилгаж, социализмийн залгамж болон өөрчлөн байгуулалтыг өрнүүлсээр, жинхэнэ тусгаар тогтнолоо олохыг зорьж байгааг нь илэрхийлж буй юм.

Гэхдээ, энэ ардчилсан хөдөлгөөн нь 1990 оны эцсээр төгөсгөлрүүгээ хандсан юм. Олон улсын валютын сан Монголд “халдан орж”, хэвийн биш байдал, гажуудлыг сэдээсэн юм (Монгол улс ОУВСанд 1991 онд элсэн орсон).

Олон улсын валютын сан зэргийн зорилго нь Жефри Сакс (Америкийн эдийн засагч)-ийн “Шёкоор эмчлэх арга” (Нийтийн эмх замбараагүй байдал, эдийн засгийн самуун) –аар хийгдсэн социалист эдийн засгийн задрал байлаа.

Энэ үеийн нөхцөл байдлыг тодорхой илэрхийлэл нь Жемс Бейкерийн хэлсэн үг юм.



“

(Ерөнхий сайд Бямбасүрэн, АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Ж.Бейкер нар)

Тэр, өөрийгөө Монголоор өвчилсөн хүн гэж нэрлэсэн боловч 1991 оны 7 дугаар сарын 26-нд Улсын бага хурал, Ардын их хурлын хамтарсан чуулганд хэлсэн үгэндээ Монгол улс “ардчилал” ба “чөлөө” зах зээлд шилжих шаардлагатай тухай, “ардчилал”-ыг хөгжүүлэх явцад нийтийн эмх замбараагүй явдал болон эх захгүй байдал гарах тухай, “захиргаадалт” болон төлөвлөгөөт эдийн засгийн “алдаа”-ны өв нь түүний төлөөх хүчин чармайлтанд саад учруулах тухай, “зах зээл”, “чөлөөт худалдаа”, “хөрөнгө оруулалт”-нд хүчин чармайлт гаргах хэрэгтэй бөгөөд энэ тал дээр АНУ-аас тусламж үзүүлэх ба бусад “чөлөөт” орнууд ч туслах тухай, хувьчлал (хувийн өмчжүүлэх)-д “тусламж” болгож 2,4 сая долларын техник технологийн тусламж үзүүлэх тухай, Америкийн хувийн хөрөнгийг Монголд оруулах явдлыг хөхүүлэн дэмжиж, энх тайвны корпусынханаар хэлний болон компьютерийн сургалт явуулах тухай, бусад улс орнууд, Дэлхийн банк болон Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банктай хамран ажиллаж “туслах” тухай, ялангуяа Япон, Солонгосын “тусламж” хамгийн чухал болох тухай, (1991 оны 7-р сараас) хоёр сарын дараа Монгол болон хандивлагч орнуудын хурал болно гэдэгт найдаж байгаа тухайгаа дурьджээ. Монгол улс түүний тодхойлсон чиглэлийн дагуу урагшилсан юм.

U.S. DEPARTMENT OF STATE
Office of the Assistant Secretary/Spokesman
(Ulaanbaatar, Mongolia)

EMBARGOED FOR RELEASE
UNTIL DELIVERY

REMARKS
BY
THE HONORABLE JAMES A. BAKER, III
BEFORE
JOINT MEETING
OF
BAGA HURAL AND IKH HURAL
ULAANBAATAR, MONGOLIA
FRIDAY, JULY 26, 1991

Thank you, Mr. Vice President. Ladies and Gentlemen:

Today, I come to speak to you as an American, a Texan, and an outdoorsman.

As an American, I believe in democracy and free markets. And so on behalf of President Bush and the American people, I come here today to lend our support and to work with you for the success of political and economic freedom here in Mongolia.

As a Texan, I believe in the strength that comes from life on the frontier. And so I come to your land, twice the size of my home state and one of the world's last frontiers, to support the Mongolian people's hard work for freedom and to say to you: There can be no turning back on freedom's road.

As an outdoorsman, I believe in the wonder of nature. And so I come to your breath-taking country to marvel at the gifts God has given it and to take back to the American people tales of its splendor and beauty.

And, above all, I come here today to finish the visit we began together a year ago, a visit the warm hospitality of which my delegation and I will never forget, a visit that I am privileged in a sense to continue by addressing this distinguished body today.

When last I was honored to be here in Ulaanbaatar, it was to join in the high-spirited festivities celebrating your historic elections. This people, seemingly so cut off from the peaceful democratic revolutions of 1989, had just chosen to join those revolutions and build democracy. This nation, seemingly so remote from the world, had just chosen to join the growing community of free nations.

But, in stark contrast to your courageous choice, Iraq's brutal decision to invade Kuwait -- a throwback to dictatorship and aggression -- cut short our mutual celebration of Mongolia's new-found freedom. Neither the President, nor the American people nor I, will forget how quickly and strongly Mongolia condemned Iraq's brutality and worked with the international community to end Saddam Hussein's aggression.

(1991 оны 7-р сарын 26-ны өдөр Улсын бага хурал, Ардын их хурлын нэгдсэн хуралдаанд

Ж.Бейкерийн хэлсэн үгийн эх)

Гэхдээ 1990 оны үеийн Монгол улсад хямрал туйлдаа хүрч, ядуурал болон нэг хэсэг давхрагын баяжилт зэрэг явагдаж байсны учир юунд байв.

Ерөнхий сайд Бямбасүрэн (1990-1992) Олон улсын валютын сангийн стратегийг авч ашиглан, хувьчлал (хувьцааны хэлбэрээр 1991-1995, дуудлага худалдаа 1995 оноос өнөөг хүртэл)-ыг эрчимжүүлж, төрийн өмчийг хэсэгчлэн худалдах, нэгдэл, САА-г задлах, эдийн засгийн дэд бүтэцийн сүйрлийг эрчимжүүлэв. Нөгөө талаар, нийгмийн хамгааллын зардал, ард иргэдийн амьжиргааны зардлыг танаж, эдийн засгийн өсөлтийг гол зорилтонд нь хүргэв. Гэвч, нөхцөл байдал тэр дагуу нь явсангүй, дайны үеийн эдийн засаг дахин илэрсэн мэт гол нэрийн барааг картын системд оруулахаас өөр аргагүй байдалд хүрэв.

Мөн, нийгмийн тогтворгүй байдал болон ялзрал даамжирав. Ардчилсан хөдөлгөөнд оролцож явсан хүмүүс эрх баригч нам болсон Ардчилсан холбоо эвслийн засгийн газар (1996-2000)-ын үед авилга хээл хахууль (арилжааны банкуудыг нийлүүлсэн хэрэг), улс төрийн тогтворгүй байдал (Зоригийн аллага), эдийн засгийн уналт (гаалийн татварыг тэглэх тогтолцоо) дээд шатандаа хүрсэн юм.

Иймэрхүү байдал дунд, Монголд ядуурал газар авсаар байлаа. Үүний шалтгаан нь Олон улсын валютын сангийн зөвлөмжийн дагуу үйлдвэр, аж ахуйг задран бутаргаж, ажилгүйдэл

ихэдсэний дээр улсаас үзүүлэх тусламж үгүй болж, “өөрөө өөртөө туслах”-аас өөр аргагүй болсон үед нь байгалийн гамшиг зуд болж малгүй болсон иргэд хот суурин бараадах болсон нь ажилгүйдэл, нийгмийн аюулгүй байдлыг муутгахад хүргэсэн гол шалтгааны нэг нь юм.


1990 оноос өмнө улс төрийг дангаар барьж ирсэн улс төрийн нам (МАХН) 1996 оны улсын их хурлын сонгуульд ялагдаж, сөрөг хүчин болов. Үүндээ дүгнэлт хийсэн тус нам мөрийн хөтөлбөрөө өөрчилж, ардчилсан социалист үзэл баримтлалыг мөрдөх болов. Түүний дараа МАХН нэг хэсэг хугацаа (1996-2000)-г эс тооцвол төр барьж байлаа.

Түүний үр дүн болон асуудалтай талыг авч үзье. 2000 оны их хурлын сонгуулиар ардчилсан хүчний холбоонд ялагдсан МАХН-ыг Энхбаяр толгойлж байлаа. Тэрээр, “Тал нутгийн Бүрээ (Английн ерөнхий сайд)”-г дууриаж Монголд ардчилсан социалист үзлийг тогтооно хэмээн тунхаглаад, “хувьчлал”-д тулгуурласан нийгмийн өөрчлөлийг зорьсон юм.



Enkhbayar celebrates his victory

(МАХН-ын дарга Энхбаяр)



(А.Цанжид “Ардчилсан социализм”)

Гэвч, Олон улсын валютын сангаас зугтааж чадаагүйгээр барахгүй түүний чиг шугамыг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр, харин ч баян, ядуугийн ялгаа ихдэв.

Энэ явц дундаас иргэний хөдөлгөөн өрнөн гарч ирэв (2004-2008). Иргэний хөдөлгөөн нь “Авилга хээл хахуулийн эсрэг”, “Баян, хоосны ялгааг арилгах”, “Газрын баялагыг ард түмний гарт” гэсэн уриалга гарган ялангуяа Улаанбаатарчуудын дэмжлэгийг авч чадсан юм. Гэвч, эцэст нь тэд хүчирхийлэл хэрэглэх болсноор (үүний нэг томоохон жишээ нь МАХН-ын төв байрыг галдан шатаасан 2008 оны 7-р сарын 1-ний хэрэг юм) ард түмний дэмжлэгээсээ хагацсан юм.



(“Эрүүл нийгэм, иргэний хөдөлгөөн”-өөс зохион байгуулсан жагсаал)



(С.Ганбаатар. Үйлдвэрчний хөдөлгөөний идэвхтэн болсон)

МАХН (Намынхаа нэрийг өөрчилж одоо МАН болсон) С.Баярын удирдлагаар намын шинэчлэл болон социалист чиг шугамыг барих болов. С.Баяр нь эдийн засгийн бие даасан байдлыг хангах (атрын гуравдугаар аян), хариуцлага сахилга батыг (Авилгатай тэмцэх) сайжруулахыг зорив.



Монгол улсын Улсын Бага хурлын гишүүн
Д.Батсүх, Д.Ганболд, С.Баяр

(Баруун гар талаас залуухан С.Баяр, тухайн үеийн шадар сайд Д.Ганболд)

Ингээд, 2008 оны Их хурлын сонгуулиар олонх болсон ч гэсэн МАХН, АН хоёр эвслийн засгийн газар байгуулав (2008-2012). Энэ нь уул уурхайг хөгжүүлэхтэй холбоотой ард түмний

нэгдсэн хүсэл эрмэлзлээс үүдэлтэй байв. Өөрөөр хэлбэл, улс төрийн намуудын задрал, бутралаас зайлсхийх социалист маягын бодлого байлаа.



(Атрын гурав дахь аяны үеийн тариалангийн талбай)



(УИХ-ын 2008 оны сонгуулийн үеийн сурталчилгаа. Зүүн гараас, С.Баяр, С.Батболд нар. Аль аль нь Сүхбаатар дүүргээс сонгогдсон)

Одоо Монгол улс нуугдмал байсан “Ашигт малтмалын их гүрэн” гэгдэх болов.

Ашигт малтмалын тухай шинэ хууль (2006) батлагдсан боловч үүнийг иргэний хөдөлгөөний шаардлага (Уул уурхайн баялагыг ард түмэнд)-д нийцүүлсэн хууль юм.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ (Шинэчилсэн найруулга) НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 2 дугаар зүйл. Хууль тогтоомж 2.1. Ашигт малтмалын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчныг хамгаалаа тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль, здүгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. 2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө. 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ 3.1. Энэ хуулиар ус, газрын тос, байгалийн хийгээс бусад төрлийн ашигт малтмал эрх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна. 3.2. Гар аргаар болон бичил уурхайгаас ашигт малтмал ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна. 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 4.1.1. "ашигт малтмал" гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд үүсч бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлалыг; 4.1.2. "тойм судалгаа" гэж ашигт малтмал байгаа эсэхийг тогтоох зорилгоор газрын хэвлийг хөндөхгүйгээр чулуулгийн сорьц,	дээж авах, геологи, ашигт малтмалын анхдагч мэдээллийг ашиглах, агаарын зураг авах аргаар геологийн судалгаа хийхийг; 4.1.3. "улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгаа" гэж улсын төсвийн эх үүсвэрээр гүйцэтгэж байгаа геологийн зураглал, сэдэвчилсэн судалгаа болон геологийн эрэл, хайгуулын ажлыг; 4.1.4. "ашигт малтмал эрх" гэж ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд эрдсийн хуримтлал байгаа эсэхийг тогтоох зорилгоор хийгдэж байгаа геологийн судалгааны ажлыг; 4.1.5. "ашигт малтмал хайх" гэж эрдсийн хуримтлалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, түүний нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийхийг; 4.1.6. "ашигт малтмал ашиглах" гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг; 4.1.7. "хайгуулын ажлын зардлын доод хэмжээ" гэж хайгуулын ажиглалд жил бүр зарцуулсан байвал зохих зардлын доод хэмжээг; 4.1.8. "ашигт малтмалын орд" гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадарга, түүний хэвлийд бүрэлдэн тогтох чанар, нөөц нь тодорхойлогдсон, үйлдвэрийн аргаар олборлоход эдийн засгийн хувьд ашигтай эрдсийн хуримтлалыг; 4.1.9. "ашигт малтмалын үндсэн орд" гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд бүрэлдэн тогтох анхлан үүссэн чулуулгайгаар нэг орон зайд байрлаж байгаа эрдсийн хуримтлалыг; 4.1.10. "ашигт малтмалын шороон орд" гэж анхлан үүссэн чулуулга, орон зайнаасаа өгөршил, элэгдэл, механик үйл явцын дүнд сарнин салж, дахин хуримтлагдаж улмаар үе, давхарга байдлаар байгаа эрдсийн хуримтлалыг; 4.1.11. "стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд" гэж үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг;
---	---

(2006 онд шинэчлэн сайжруулсан “Ашигт малтмалын тухай хууль”. Эхлэл хэсэг.)

Монгол улс уул уурхайг улсын стратеги болгохыг зорьж байна. Тиймээс “Хүний хөгжлийн сан” хэмээх сан байгуулж, төрийн өмчийн уул уурхайгаас орсон ашигаас ард түмэндээ шууд хувиарлах бодлого хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ бүхний суурь болгож дэд бүтэцийг хөгжүүлж байна. Энэ нь үндсэндээ социалист маягын шинж чанар агуулдаг.